

ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ИНД-175-ИЙН ХАРЬЦУУЛАЛТ

<p>Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт <i>(Шинэчлэгдэж байгаа)</i> /21 хуудас NZ Part 175-ийн 2017 оны 03 сарын 10-ны А.8-д үндэслэсэн/</p>	<p>АГААРЫН НАВИГАЦИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНИКИЙН БАЙГУУЛЛАГА - ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ /29 хуудас Хүчинтэй мөрдөгдөж байгаа 2003 оны /</p>	<p>Тайлбар</p>
<p>А Бүлэг - Ерөнхий зүйл</p>	<p>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</p>	
<p>175.1. Хамрах хүрээ Энэ Дүрэм нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно: (1) Монгол Улсад Нисэхийн Мэдээллийн Үйлчилгээ үзүүлдэг байгууллагын гэрчилгээжүүлэлтийн болон үйл ажиллагааны; (2) Монгол Улсын AIP, AIC болон NOTAM-ын.</p>	<p>175.1. Зорилго (а) Энэ дүрмийн зорилго нь Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагыг гэрчилгээжүүлэх, түүний үйл ажиллагаанд болон нисэхийн мэдээллийн нэгдсэн багцын элементүүдэд тавигдах шаардлагыг тогтооход оршино.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан -Amend.3-аар нэмэгдсэн</p>
<p>175.3 Гэрчилгээний шаардлага Аливаа этгээд энэ Дүрмийн дагуу олгосон нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын (цаашид "НМҮБ" гэх) гэрчилгээний эрх болон нөхцөлд заагаагүй НМҮ-г Монгол Улсын FIR-д үзүүлэхгүй.</p>	<p>175.5. Гэрчилгээжүүлэлтийн шаардлага (а) Энэ дүрмийн дагуу Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллага (цаашид НМҮБ гэх)-ын гэрчилгээ эзэмшигчээс өөр бусад байгууллага, этгээд Монгол Улсын нислэгийн мэдээллийн районд нисэхийн мэдээллийн үйлчилгээ (цаашид НМҮ гэх) эрхлэхийг хориглоно.</p>	<p>-Нэр томъёоны тайлбар, тодорхойл олтууд ИНД-1-д орсон.</p>
<p>175.5. Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах НМҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь САА 24175/01 маягтыг бөглөж, дараах баримтын хамт Даргад хүргүүлнэ: (1) 175.69-д шаардсан Ерөнхий заавар; (2) зохих төлбөрийн баримт.</p>	<p>175.7. Өргөдөл гаргах (а) НМҮБ-ын гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч (цаашид Өргөдөл гаргагч гэх) нь ИНЕГ-175/01 маягтыг бөглөн энэ дүрмийн 175.69-д заасан Үйл ажиллагааны зааврыг төлбөрийн баримтын хамт Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид ИНЕГ гэх)-ын даргад ирүүлнэ.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан -Amend.1-ээр нэмэгдсэн</p>
<p>175.7 Гэрчилгээ олгох Хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, хүсэлт гаргагч нь НМҮБ-ын гэрчилгээ эзэмших эрхтэй (1) хүсэлт гаргагч В Бүлгийн шаардлага хангасан байх; (2) хүсэлт гаргагч болон 175.51(а)(1) (2)-т шаардсан хүсэлт гаргагчийн удирдах ажилтан, эсхүл ажилтнууд нь тохирох зөв хүн байх; (3) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх.</p>	<p>175.9. Гэрчилгээ олгох (а) ИНЕГ-ын дарга нь НМҮБ-ын гэрчилгээг дараах нөхцөлд олгоно: 1/ өргөдөл гаргагч энэ дүрмийн Б бүлгийн шаардлагыг хангасан байх; 2/ өргөдөл гаргагч болон түүний удирдах албан тушаалтан, эсхүл энэ дүрмийн 175.51-ын (а)-ийн 1/, 2/-т заасан ажилтнууд нь тухайн ажлын байранд тавих шаардлагад нийцэж тохирсон байх; 3/ гэрчилгээ олгосноор нисэхийн аюулгүй</p>	<p>-Орчуулга, найруулга зассан - Amend.1-ээр нэмэгдсэн</p>

	ажиллагаанд <u>сөргөөр нөлөөлөхгүй</u> ;	
175.9. Гэрчилгээ <u>эзэмшигчийн</u> эрх НМҮБ-ын гэрчилгээнд, тухайн гэрчилгээ эзэмшигчид зөвшөөрсөн НМҮ-г заана.	175.11. Гэрчилгээгээр <u>олгогдох</u> эрх (а) Гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээнд тусгагдсан Нисэхийн мэдээллийн үйлчилгээг эрхлэх эрхтэй.	-Amend.1-ээр нэмэгдсэн
175.11 Гэрчилгээний хугацаа (а) НМҮБ-ын гэрчилгээг <u>5 жил</u> хүртэл хугацаагаар олгож, эсхүл <u>сунгаж болно</u> . (б) НМҮБ-ын гэрчилгээ нь түүний хугацаа дууссан, түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос бусад тохиолдолд хүчинтэй хэвээр байна. (с) НМҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хугацаа дууссан, эсхүл хүчингүй болсон тохиолдолд гэрчилгээг <u>Даргад</u> нэн даруй хураалгана. (д) Гэрчилгээг түдгэлзүүлсэн тохиолдолд НМҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь зохих баталгаажуулсан бичилт хийлгэхээр <u>Даргад</u> нэн даруй хүргүүлнэ.	175.13. Гэрчилгээний хугацаа (а) Гэрчилгээг <u>3 жил</u> хүртэлх хугацаагаар олгоно. (б) Гэрчилгээ нь түүний хүчинтэй хугацаа дууссан, эсхүл <u>ИНЕГ</u> -аас гэрчилгээний үйлчлэлийг түр түдгэлзүүлсэн буюу хүчингүй болгосноос бусад тохиолдолд хүчин төгөлдөр байна. (в) Гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан, эсхүл хүчингүй болсон тохиолдолд гэрчилгээг <u>ИНЕГ</u> -ын даргад ирүүлнэ. (г) Гэрчилгээний үйлчлэлийг түр түдгэлзүүлсэн тохиолдолд тухайн гэрчилгээг сэргээх асуудлаар гэрчилгээ эзэмшигч нь <u>ИНЕГ</u> -ын даргад хандаж болно.	-Орчуулга, найруулга зассан
175.13 Гэрчилгээ сунгах (а) НМҮБ-ын гэрчилгээ сунгуулах <u>хүсэлтийг</u> САА 24175/01 маягтын дагуу гаргах ёстой. (б) Хүсэлтийг тухайн гэрчилгээнд сунгах заасан хугацаанаас өмнө, эсхүл хэрэв сунгах хугацаа заагаагүй бол гэрчилгээний хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө <u>Даргад</u> хүргүүлэх үүрэгтэй.	175.15. Гэрчилгээний <u>хугацаа</u> сунгах (а) Гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгуулах <u>өргөдлийг</u> ИНЕГ-175/01 маягтын дагуу гаргаж, гэрчилгээний хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө <u>ИНЕГ</u> -ын даргад ирүүлнэ.	-Орчуулга, найруулга зассан
В Бүлэг - Гэрчилгээжүүлэлтийн шаардлага	Б БҮЛЭГ. ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА	
175.51. <u>Ажилтанд</u> тавих шаардлага (а) НМҮБ-ын гэрчилгээ эзэмших <u>хүсэлт гаргагч нь</u> дараах ажилтныг үндсэн ажилтнаар, эсхүл гэрээгээр ажиллуулах үүрэгтэй: (1) хүсэлт гаргагчийн <u>Ерөнхий</u> зааварт заасан НМҮ бүрийг дараах байдлаар гүйцэтгэхээ тухайн байгууллагын хүрээнд бататгах үүрэгтэй <u>Гүйцэтгэх захирлын албан тушаалд</u> томилогдсон удирдах ажилтан:	175.51. <u>Боловсон хүчинд</u> тавигдах шаардлага (а) Өргөдөл гаргагч нь дараах албан тушаалтан, ажилтантай байна: эрхэлж байгаа НМҮ, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь энэ дүрмийн шаардлагад нийцэж байгаа болон зохих шаардлагын дагуу санхүүжиж байгааг бататгах эрх бүхий <u>удирдах албан тушаалтан</u> ;	-Орчуулга, найруулга зассан

<p>(i) үйл ажиллагааны шаардлагад нийцүүлэн, санхүүжүүлж чаддаг байх;</p> <p>(ii) энэ Дүрэмд заасан шаардлагын дагуу үзүүлдэг байх;</p> <p>(2) дараах үйл ажиллагааны чиглэлээр <u>Гүйцэтгэх захирлын өмнө эцсийн хариуцлага хүлээх удирдах ажилтан, эсхүл ажилтнууд:</u></p> <p>а. <u>тухайн байгууллага нь Ерөнхий заавартаа нийцэж байгааг бататгах;</u></p> <p>б. <u>175.67-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо;</u></p> <p>(3) <u>Ерөнхий заавартаа заасан НМҮ-нд зориулсан нисэхийн мэдээллийг цуглуулах, эмхлэх, шалгах, зохицуулах боловсруулах болон хэвлэн нийтлэх хангалттай тооны ажилтан.</u></p> <p><u>(аа) Энэ зүйлийн (а)(2)(ii)-т шаардсан удирдах ажилтан нь гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа болон аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой холбоотой үр чадвар туршлагаа харуулсан байх үүрэгтэй.</u></p> <p><u>(b) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй</u></p> <p>(1) <u>Ерөнхий заавартаа заасан НМҮ-нд зориулсан нисэхийн мэдээллийг шалгах, боловсруулах болон хэвлэх зорилгоор хүсэлт гаргагчийн эрх олгосон ажилтны үр чадварын анхны үнэлгээг хийх журмыг тогтоох;</u></p> <p>(2) <u>эрх бүхий ажилтны үр чадварыг хадгалах журмыг тогтоох;</u></p> <p>(3) <u>эрх бүхий ажилтанд, түүний эрхийн хүрээг тодорхойлсон нотлох баримтыг бичгээр олгох.</u></p>	<p>байгууллагын үйл ажиллагааг энэ дүрмийн шаардлагад нийцүүлж явуулах үүрэг бүхий өөрийн <u>удирдах албан тушаалтны</u> өмнө хариуцлага хүлээх ажилтнууд;</p> <p>эрхлэх НМҮ-нээс хамааран нисэхийн мэдээллийг цуглуулах, харьцуулан үзэх, нэгтгэх, шалгах, зохицуулах, боловсруулах, хадгалах, хэвлэх үйл ажиллагааг гүйцэтгэх эрх олгогдсон <u>хангалттай тооны</u> боловсон хүчинтэй байна.</p> <p><u>(б) Өргөдөл гаргагч нь дараах журмыг тогтоож мөрдөнө: НМҮ-ний ажилтныг сонгон шалгаруулах, сургаж, дадлагажуулах журам; НМҮ-ний ажилтны мэргэжлийн үр чадварыг хадгалах, дээшлүүлэх журам; Энэ зүйлийн 175.51-ийн (а)-хэсгийн 3/-т заасан ажилтнуудад тухайн ажлыг гүйцэтгэх эрх олгох журам;</u></p>	<p>-Amend.1-ээр нэмэгдсэн</p>
<p>175.53. <u>Байгууламжийн шаардлага</u> <u>НМҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь</u> дараах ажлын байр болон байгууламжтай байна:</p>	<p>175.53. <u>Ажиллах орчинд тавигдах шаардлага</u> (а) Өргөдөл гаргагчийн ажлын байр нь эрхлэх нисэхийн мэдээллийн үйлчилгээний төрөл болон энэхүү</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

(1) Ерөнхий заавартаа заасан НМҮ-нд тохирсон;
(2) 175.103(b) болон 175.105-ын холбогдох шаардлагыг хангасан.

дүрмийн шаардлагад нийцсэн байна:

- 1/ нисэх багт нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ (цаашид НӨМҮ гэх) үзүүлэхэд ойр, тусгайлан тоноглогдсон танхим;
- 2/ НМҮ-ний ажилтныг сургаж, дадлагажуулахад зориулан тусгайлан тоноглогдсон танхим;
- 3/ НМҮ-ний бүтээгдэхүүнийг хэвлэх, ангилж, ялгахад зориулан тоноглогдсон өрөө;
- 4/ ээлжийн ажилтнууд алжаал ядаргаагааг тайлахад зориулагдсан амралтын өрөө;
- 5/ ээлжийн ажилтнууд хувцсаа солиход зориулсан шүүгээ;
- 6/ НМҮ эрхлэхэд зайлшгүй шаардлагатай дараах тоног төхөөрөмж, хэрэгсэлтэй байна:
 - 6.1. гадаад орнуудын НМҮБ болон Монгол Улсын нислэгийн мэдээллийн районы нислэгийн мэдээллийн төв, бүсийн удирдлагын төвүүдтэй харилцах хоёр талын холбооны AFTN сүлжээ;
 - 6.2. нисэх баг, нислэгийн үйл ажиллагаанд оролцогч байгууллага, хүмүүсийг шаардлагатай мэдээллээр найдвартай, түргэн шуурхай хангах зориулалт бүхий AFTN сүлжээнд холбогдсон мэдээллийн автомат систем;
 - 6.3. цахилгаан эрчим хүчээр найдвартай хангах хэрэгсэл;
 - 6.4. өндөр хурдны интернет сүлжээнд холбогдсон шаардлага хангахуйц хурд, багтаамжтай компьютер, хэвлэх төхөөрөмж;
 - 6.5. газрын зураг, зураг зүйн бүтээгдэхүүн хэвлэх төхөөрөмж;
 - 6.6. саадын мэдээллийн сан бүрдүүлэх боломжтой тоон газрын зураг;
 - 6.7. олон улсын цагийг харж тооцох зориулалт бүхий ханын цаг;
 - 6.8. мэдээлэл хүлээн авах, дамжуулах гадаад, дотоод гарцтай, соронзон бичлэг хийх телефон утсан холбоо;
 - 6.9. мэдээлэл хүлээн авах, дамжуулах төхөөрөмж /факс/;

-Amend.2-оор хүчингүй болсон

	<p><u>6.10. мэдээллийг олшруулан хувилах машин.</u> <u>(б) Энэ зүйлийн (а) хэсгийн 6/-д заасан тоног төхөөрөмжүүдийн гэнэтийн саатал, татгалзал, ашиглалт ба хүчин чадлын түвшингийн бууралт, нислэгийн аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлөх магадлалыг багасгахад зориулагдсан нөөц тоног төхөөрөмжтэй байна.</u></p>	
<p>175.55 Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээний хамрах хүрээ Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор <u>НМҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Ерөнхий заавартаа</u> заасан нислэгийн өмнөх үйлчилгээнд <u>зориулж дараах бүс, замыг заана:</u> (1) газар зүйн бүс; (2) аэродром болон тухайн аэродромоос эхлэлтэй агаарын зам.</p>	<p>175.55. Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээний хамрах хүрээ (а) <u>Өргөдөл гаргагч нь үйл ажиллагааны</u> заавартаа тусгагдсан Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ (цаашид НӨМҮ гэх)-ний <u>хамрах хүрээг тогтоосон</u> газарзүйн бүс болон аэродромууд ба тэдгээрээс эхлэх агаарын замуудыг тус тус өргөдөлдөө тодорхой заана.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>175.57. <u>Баримт бичиг</u> (а) НМҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна: (1) тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд хэвлэн нийтэлдэг нисэхийн мэдээллийн формат болон стандартыг тогтоох; (2) тухайн формат болон стандарт нь мэдээллийг ашиглах нөхцөл байдлыг тооцон үздэг болохыг бататгах; (3) Ерөнхий заавартаа заасан НМҮ-нд шаардлагатай лавлагааны материал, стандарт, зөвлөмж, журам болон бусад холбогдох баримт бичгийн хувийг хадгалдаг байх. (б) Хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг бататгах зорилгоор энэ зүйлийн (а)-д шаардсан бүх баримт бичгийг хянах журмыг тогтоосон байна: (1) баримт бичгийг боловсруулж гаргахаас өмнө холбогдох ажилтан хянаж, зөвшөөрдөг байх; (2) Ерөнхий заавартаа заасан НМҮ-нд ашиглахад шаардлагатай холбогдох баримт бичгийн хүчинтэй хувийг тухайн баримт бичиг шаардлагатай бүх байрлалд ажилтан авч ашиглахад бэлэн байлгах; (3) хүчингүй болсон баримт бичгийг боловсруулж</p>	<p>175.57. <u>Баримтжуулалт</u> (а) Өргөдөл гаргагч нь: гэрчилгээгээр олгогдох эрхийн дагуу хэвлэвэл зохих нисэхийн мэдээллийн маягт болон загварыг баримтжуулна; нисэхийн мэдээллийн маягт болон загвар нь мэдээллийг ашиглах онцлог нөхцөлд нийцсэн байхыг бататгана; үйл ажиллагааны зааварт тусгагдсан НМҮ эрхлэхэд шаардлагатай лавлах материал, стандарт, зөвлөмж, журам болон бусад баримт бичгийн хуулбаруудыг бэлэн байлгана. (б) Өргөдөл гаргагч нь энэ зүйлийн (а) хэсэгт заасан баримт бичгүүдийг хянах зорилгоор дараах зүйлсийг тусгасан журамтай байна: баримт бичгийг хэвлэхээс өмнө түүний хангалттай эсэхийг зохих ажилтан хянан баталгаажуулж байх; баримт бичигт дүн шинжилгээ хийж, шаардлагатай бол шинэчилж байх; баримт бичгийн өөрчлөлт, хянаж шинэчилсэн төлөв байдлыг ил тод тодорхой байлгах; хэрэгцээт баримт бичгийг хэрэглэх газарт зохих хувилбараар нь бэлэн байлгах;</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>гаргасан, эсхүл ашиглаж байгаа цэг бүрээс нэн даруй хураан авдаг байх;</p> <p>(4) баримт бичигт орсон өөрчлөлтийг холбогдох ажилтан хянаж, бататгадаг байх;</p> <p>(5) хугацаа нь дууссан хэвлэлтийг ашиглахаас сэргийлж баримт бичгийн хуудас бүрийн хүчинтэй хувилбарыг таньж тогтоож болдог байх.</p>	<p>баримт бичиг нь гаргацтай, тод бөгөөд ялган таньж олоход хялбар байлгах;</p> <p>гадны гарал үүсэлтэй баримт бичгийг бүртгэн тодруулж тэдгээрийн түгээлтийг хяналттай байлгах;</p> <p>хуучирсан баримт бичгийг хэрэглэхээс сэргийлж, түүнийг аливаа нэгэн зорилгоор хадгалж байгаа бол тухайн баримт бичгийг сайтар бүртгэн тэмдэгжүүлэх.</p>	
<p>175.59 Мэдээлэл цуглуулах</p> <p>(a) НМҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Ерөнхий заавартаа заасан НМҮ-нд шаардлагатай мэдээллийг цуглуулах болон эмхлэх журмыг тогтоосон байна.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-д заасан журам нь дараах шаардлагыг бататгасан байна:</p> <p>(1) холбогдох мэдээллийг Монгол Улсын агаарын навигацийн системийг дэмжих үйлчилгээ үзүүлдэг байгууллагаас авдаг байх;</p> <p>(2) Монгол Улсаас эхлэлтэй олон улсын агаарын замд нислэг үйлдэж байгаа, олон улсын агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн шаардлагад хамаарах холбогдох мэдээллийг бусад Улсын НМҮБ-ын авдаг байх;</p> <p>(3) цаг тухайд нь мэдээллээр хангах зохицуулалтыг энэ зүйлийн (b)(1) болон (2)-т заасан мэдээлэгч байгууллагатай хамтран хийдэг байх;</p> <p>(4) энэ зүйлийн (b)(1)-д заасан мэдээлэгч байгууллагаас хүлээн авсан мэдээллийг тухайн мэдээллийн нарийвчлалыг хариуцсан мэдээлэгч байгууллагын томилсон этгээд үнэн зөв болохыг баталгаажуулдаг байх.</p> <p>(c) Энэ зүйлийн (b)-д зааснаас гадна, NOTAM үйлчилгээний журам нь NOTAM гаргах аливаа мэдээлэгч байгууллагын хүсэлтийг тухайн NOTAM-ыг 3 сараас дээш хугацаагаар хүчинтэй байхыг шаарддаггүй болохыг бататгана.</p>	<p>175.59. Мэдээлэл цуглуулах</p> <p>(a) Өргөдөл гаргагч нь НМҮ эрхлэх үйлчилгээнд шаардлагатай мэдээллийг цуглуулах, харьцуулан дүгнэх журмыг тогтоож, Үйл ажиллагааны заавартаа тусгана.</p> <p>(б) Энэ зүйлийн (a)-д заасан журам нь дараах зүйлсийг тусгасан байна:</p> <p>цуглуулах түүхий мэдээлэлд тавигдах шаардлагыг тогтоосон байх;</p> <p>шаардлага хангасан мэдээллийг Монгол Улсын агаарын навигацийн тогтолцоонд үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудаас хүлээн авсан байх;</p> <p>Монгол Улсаас эхлэх олон улсын нислэгийн үйл ажиллагаанд ашиглагдах холбогдох мэдээллийг бусад улсын НМҮБ-аас хүлээн авсан байх;</p> <p>Нислэгийн өмнөх болон нислэгийн үед шаардлагатай мэдээллийг мэдээллийн бусад баталгаат эх үүсвэрээс авсан байх;</p> <p>энэ зүйлийн (б) хэсгийн 2/, 3/-т дурьдсан мэдээлэгч байгууллагууд нь мэдээллээр цаг тухайд нь хангаж байх талаар харилцан тохиролцсон байх;</p> <p>энэ зүйлийн (б) хэсгийн 2/-т заасан мэдээлэгч байгууллагуудаас хүлээн авсан мэдээлэл нь тухайн байгууллагаас томилогдсон, мэдээллийн үнэн зөвд хариуцлага хүлээх албан тушаалтнаар баталгаажуулагдсан байх;</p> <p>ирүүлсэн түүхий мэдээлэл нь NOTAM мэдээгээр зарлагдах бол хүчин төгөлдөр байх хугацааг 3 сараас дээшгүй байхаар тусгах.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>175.61. Нисэхийн мэдээллийг хэвлэн нийтлэх</p> <p>(a) НМҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Ерөнхий</p>	<p>175.61. Нисэхийн мэдээллийг хэвлэх</p> <p>(a) Өргөдөл гаргагч нь НМҮБ-ын эрхлэх үйлчилгээнд</p>	

заавартаа заасан үйлчилгээнд ашиглах нисэхийн мэдээллийг шалгах, зохицуулалт хийх, боловсруулах, хэвлэн нийтлэх болон түгээх журмыг тогтоосон байх үүрэгтэй.

(b) Хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (a)-ийн дагуу тогтоосон журамд дараах шаардлагыг заасан болохыг бататгах үүрэгтэй:

(1) 175.59-д заасны дагуу хүлээн авсан мэдээллийг хэвлэн нийтлэхийн өмнө боломжит мэдээлэл ашиглан түүний үнэн зөвийг бататган, шалгадаг байх;

(2) 175.59-д заасны дагуу хүлээн авсан мэдээллийг дараах хэлбэрээр боловсруулдаг, үнэн зөв хэвлэн нийтэлдэг болон түгээдэг байх:

(i) тухайн мэдээллийн үйл ажиллагааны ач холбогдолд тохирсон форматаар;

(ii) хамааралтай бол D, E, эсхүл F Бүлгийн дагуу;

(iii) тухайн мэдээллийг ашиглах нөхцөл байдлыг тооцон үзсэн форматаар.

(3) энэ зүйлийн (b)(4)-т зааснаас бусад тохиолдолд, байнгын шинж чанартай нийтлэл болон урт хугацаатай, түр нийтлэлийг тухайн хүсэлт гаргагчийн НМҮБ-ын гэрчилгээний эрхийн хүрээнд хэвлэн нийтэлсэн болох нь тодорхой танигддаг байх;

(4) хэрэв 175.59(b)(2)-ын дагуу бусад Улсын НМҮБ-ын авсан нисэхийн мэдээллийг түгээдэг бол, тухайн мэдээллийг гаргадаг Улсын эрх бүхий байгууллагаас хүлээн авсан болохыг тодорхой таньж тогтоодог байх;

(5) хэрэв 175.59(b)(4)-т заасны дагуу үнэн зөвийг баталгаажуулаагүй мэдээллийг түгээдэг бол, тухайн мэдээллийг баталгаажуулаагүй болохыг тодорхой таньж тогтоодог байх ёстой;

(6) хэвлэн нийтэлсэн мэдээлэлд байнгын шинж чанартай өөрчлөлт оруулах тохиолдолд тухайн өөрчлөлтийг хэвлэн нийтлэхийн өмнө холбогдох

шаардлагатай нисэхийн мэдээлэл/өгөгдөл, нисэхийн мэдээллийн нэгдсэн багцын элементүүдийг үүсгэх, нэгтгэх, шалгах, зохицуулах, боловсруулах, хадгалах, хэвлэх, тараах журмыг тогтоож, Үйл ажиллагааны заавартаа тусгана.

(б) Энэ зүйлийн (a) хэсэгт заасан журам нь дараах зүйлсийг тусгасан байна:

1/ энэ дүрмийн 175.59 зүйлд заасны дагуу хүлээн авсан мэдээллийг хэвлэн гаргахаас өмнө боломжит мэдээлэл ашиглан түүний үнэн зөвийг баталгаажуулан шалгах;

2/ энэ дүрмийн 175.59 зүйлд заасны дагуу хүлээн авсан мэдээллийг боловсруулах, хэвлэх, тараах:

2.1. тохирох загварт оруулах ба энэ нь мэдээллийг ашиглах нөхцөлийг тооцсон байх;

2.2. боломжтой бол энэ дүрмийн Г, Д, Е бүлэгт заасан шаардлагад нийцүүлэх;

3/ энэ зүйлийн (б) хэсгийн 4/-т зааснаас бусад тогтмол болон урт хугацаатай, түр шинж чанартай хэвлэл нь өргөдөл гаргагчид олгогдсон эрхийн дагуу хэвлэгдсэнийг илэрхийлсэн тэмдэглэгээтэй байх;

4/ хэрэв энэ дүрмийн 175.59 зүйлийн (б) хэсгийн 2/-т заасны дагуу бусад орны НМҮБ-с хүлээн авсан нисэхийн мэдээллийг тараах тохиолдолд тухайн орны эрх бүхий байгууллагаас хүлээн авсан гэдгийг тодорхойлох тэмдэглэгээтэй байх;

5/ энэ дүрмийн 175.59 зүйлийн (б) хэсгийн 6/-д заасан шаардлагын дагуу баталгаажуулагдаагүй мэдээллийг түгээх бол уг мэдээллийг баталгаажуулан шалгагдаагүйг тодорхойлсон тэмдэглэгээтэй байх;

6/ хэвлэгдсэн тогтмол мэдээлэлд өөрчлөлт оруулах тохиолдолд тухайн өөрчлөлтийг хэвлэхээс өмнө холбогдох бусад мэдээлэгчидтэй хэлэлцсэн байх;

-Орчуулга, найруулга зассан

-Amend.6-аар нэмэгдсэн

бусад мэдээлэгч байгууллагатай [хамтран зохицуулалт](#) хийдэг байх;

(7) мэдээлэгч байгууллагаас тухайн мэдээллийг цуцлах, эсхүл дахин гаргахыг шаардсан арга хэмжээ авдаг болохыг бататгах зорилгоор тогтоосон дуусах хугацаагүй хэвлэн нийтэлсэн түр мэдээллийг тодорхой хугацаанд хянадаг байх;

(8) нисэхийн мэдээллийг ашиглах хэлбэрээс шалтгаалан англи хэл /монгол хэл дээр хэвлэн нийтэлдэг байх;

(9) газар орны нэрийг [орон нутгийн хэллэгийн](#) дагуу үсэглэн бичих шаардлагатай тохиолдолд латин үсгээр галиглан бичих;

(10) хэмжлийн нэгж нь [ИНД-91.4-т заасантай](#) нийцсэн байх;

(11) хэвлэн нийтэлсэн нисэхийн [мэдээлэлд ИНД-ийн тайлбарт нийцсэн товчлолыг хэрэглэдэг байх](#), хэрэв:

[\(i\) хэрэглээ нь тохирч байгаа бол;](#)

[\(ii\) хэрэглээ нь мэдээллийн түгээлтийг хялбаршуулж байгаа бол;](#)

(12) [бусад Улсын НМҮБ-ын хүсэлт гаргасан тохиолдолд](#) хэвлэн нийтэлсэн аливаа нисэхийн мэдээллийг [нэн даруй дамжуулдаг байх](#);

(13) нисэхийн мэдээллийг дараах хэрэглэгчийн үйл ажиллагааны шаардлагад тохирох хэлбэрээр ашиглахад бэлэн байлгах:

7/ түр шинж чанартай мэдээллийн дуусах хугацааг нь тодорхой бусаар хэвлэсэн бол түүнийг мэдээлэгчээс

тухайн мэдээллийг цуцлах эсхүл сунгах арга хэмжээ авч болохуйц хугацааны өмнө дахин тодруулах;

8/ нисэхийн мэдээллийг хэрэглэх байдлаас нь шалтгаалан [монгол](#), англи хэлээр хэвлэх;

9/ нисэхийн мэдээллийн нэгдсэн багцад [англи](#) хэлээр хэвлэх монгол нэрийг латин үсгээр галиглаж бичих;

10/ хэмжих нэгжүүд нь [Монгол Улсын Хэмжлийн нэгжийн MNS ISO-1000:2002 стандартад](#) нийцсэн байх;

11/ хэвтээ хавтгай дахь болон босоо хавтгай дахь тооллын тогтолцоо нь [Монгол Улсын Засгийн газрын геодезийн солбилцол, өндөр, нэгдсэн тогтолцооны тогтоолтой нийцсэн байх](#);

[12/ хугацааны тооллын тогтолцоонд ашиглагдах байдлаас шалтгаалан Монгол Улсын эсхүл Гринвичийн голчийн цагийг ашиглах](#);

13/ [ИНД-1-т](#) орсон товчлол нь хэрэглэхэд тохиромжтой, мэдээллийн [түгээлтийг хялбарчилж](#) байвал хэвлэгдэх нисэхийн мэдээлэлд ашиглах;

[14/агаарын навигацийн аюулгүй ажиллагаа, тогтвортой байдал болон үр ашигтай байдлыг хангах үүднээс аливаа нисэхийн мэдээлэл/өгөгдлийг бусад орны НМҮБ-аас шаардсан тохиолдолд нэн даруй дамжуулах боломжтой байх](#);

15/ Агаарын навигацийн аюулгүй ажиллагаа, тогтвортой байдал болон үр ашигтай байдлыг хангах үүднээс аливаа нисэхийн мэдээлэл/өгөгдлийг дор дурьдсан хэрэглэгчдийн үйл ажиллагаанд шаардлагатай үед тохирох хэлбэрээр бэлэн байлгах. Үүнд:

15.1. нисэх баг, нислэгийн үйл ажиллагаа хариуцсан ажилтнууд, нислэгийн төлөвлөлт болон нислэгийн сургалт, дадлага явуулдаг

(i) нисэх багийн гишүүд болон нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээг багтаасан нислэгийн үйл ажиллагааны ажилтнууд;

(ii) НМҮ хариуцсан НХҮ-ний нэгж.

(c) Хүсэлт гаргагч нь AIR-ын үйлчилгээний журамд энэ зүйлийн (b)-д зааснаас гадна дараах шаардлага багтсан болохыг бататгах үүрэгтэй:

(1) нислэгийн зураг, AIR-ын Өөрчлөлт болон AIR-ын Нэмэлтэд хавсралтад хэвлэн нийтэлсэн үйл ажиллагааны чухал ач холбогдолтой мэдээллийг AIRAC тогтолцооны дагуу хэвлэн нийтэлдэг байх;

(2) AIRAC тогтолцооны дагуу хэвлэн нийтлэх мэдээлэл нь AIRAC товчлолыг тодорхой харуулдаг байх;

(3) AIRAC тогтолцооны дагуу хэвлэн нийтэлсэн мэдээллийг, тухайн мэдээлэл хүчинтэй болохоос 28-аас доошгүй хоногийн өмнө хэрэглэгч хүлээн авсан байхаар түгээдэг байх;

(4) AIRAC тогтолцооны дагуу хэвлэн нийтэлсэн мэдээллийг тухайн хүчинтэй өдрөөс хойш 28-аас доошгүй хоногт, мэдэгдсэн нөхцөл байдал нь түр зуурын шинж чанартай ба бүхий л цаг хугацааны түрш нөлөөлөхгүй байхаас бусад тохиолдолд өөрчилдөггүй байх;

(5) хэрэв AIR-ын Нэмэлт нь NOTAM-ыг солих зорилгоор хэвлэн нийтлэгдсэн бол, тухайн Нэмэлт нь NOTAM-ын серийн дугаарын лавлагааг багтаадаг байх;

(6) хэрэв AIR-ын Өөрчлөлт, эсхүл AIR-ын Нэмэлтийг AIRAC тогтолцооны дагуу хэвлэн нийтэлсэн бол, гарах NOTAM нь үйл ажиллагааны чухал ач холбогдолтой агуулга, хүчинтэй болох өдөр болон өөрчлөлт, эсхүл нэмэлт бүрийн лавлагааны дугаарын товч тайлбарыг өгдөг байх. NOTAM нь дараах

байгууллагууд;

15.2. нислэгийн мэдээллийн үйлчилгээ үзүүлдэг нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний нэгж болон нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээний нэгж.

(в) Өргөдөл гаргагч нь Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (цаашид НМЭ гэх)-ийн талаар дараах зүйлсийг Үйл ажиллагааны заавартаа тусгаж бататгана:

1/ НМЭ-ийн өөрчлөлт, нэмэлтээр хэвлэгдэх нислэгийн зураг болон үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой мэдээг AIRAC-ын тогтолцооны дагуу хэвлэх;

2/ AIRAC-ын тогтолцооны дагуу хэвлэгдэх мэдээлэл нь AIRAC гэсэн тэмдэглэгээтэй байх;

3/ AIRAC-ын тогтолцооны дагуу хэвлэгдсэн мэдээллийг түгээхдээ уг мэдээллийн хүчинтэй болох хугацаанаас 28 хоногийн өмнө хэрэглэгчдэд хүрсэн байхаар тооцох, цаасан хэлбэрээр бэлтгэсэн мэдээллийг нь хүчин төгөлдөр болох өдрөөс 42 хоногийн өмнө түгээх;

4/ AIRAC-ын тогтолцооны дагуу хэвлэгдсэн мэдээллийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 28 хоногийн хугацаанд түр шинж чанартай өөрчлөлт гарахаас бусад тохиолдолд өөрчлөхгүй байх;

5/ томоохон өөрчлөлт төлөвлөгдсөн үед урьдчилан мэдээлэх нь тустай тохиолдолд бололцоотой бол нисэхийн мэдээллийг хүчин төгөлдөр болохоос 56 хоногийн өмнө түгээх.

6/ NOTAM мэдээг НМЭ-ийн нэмэлтээр оруулах тохиолдолд тухайн NOTAM мэдээний дугаарыг оруулах;

7/ НМЭ-ийн өөрчлөлт болон нэмэлт нь AIRAC-ын тогтолцооны дагуу хэвлэгдсэн бол тухайн өөрчлөлт, нэмэлт тус бүрийн дугаар, хүчинтэй болох хугацаа, нислэгийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой мэдээллийн товч утгыг агуулсан NOTAM мэдээг зарлах, мөн уг NOTAM мэдээ нь:

<p>шаардлагыг хангасан байх ёстой:</p> <p>(i) тухайн өөрчлөлт, эсхүл нэмэлттэй <u>нэг өдөр</u> хүчинтэй болдог байх;</p> <p>(ii) 14 хоногийн хугацаанд хүчинтэй <u>хэвээр</u> байх;</p> <p>(7) хэрэв AIRAC-ын хугацаанд хэвлэн нийтлэх холбогдох мэдээлэл байхгүй бол, NIL гэсэн тэмдэглэгээтэй нийтэлдэг байх;</p> <p>(8) хэрэв <u>AIP</u>-ын Өөрчлөлт, эсхүл <u>AIP</u>-ын Нэмэлтээр хэвлэн нийтлэх мэдээлэл нь тухайн Өөрчлөлт, эсхүл Нэмэлт хүчинтэй болох өдрөөс өмнө хүчинтэй болох бол, NOTAM гаргадаг байх.</p>	<p>7.1. өөрчлөлт буюу нэмэлттэй нэгэн зэрэг хүчинтэй болно;</p> <p>7.2. 14 хоногийн хугацаанд хүчинтэй байна;</p> <p>8/ AIRAC-ын тогтолцооны дагуу хэвлэгдэх мэдээлэл байхгүй тохиолдолд NIL гэсэн тэмдэглэгээтэй NOTAM мэдээг тухайн AIRAC-ын хүчин төгөлдөр болох өдрөөс <u>28-аас багагүй хоногийн өмнө зарлах</u>;</p> <p>9/ мэдээллийг НМЭ-ийн өөрчлөлт болон нэмэлтийн хүчин төгөлдөр болох өдрөөс <u>өмнө ашиглаж эхлэхээр бол</u> мэдээллийг NOTAM мэдээгээр зарлах.</p>	
<p>175.63. Хэвлэн <u>нийтэлсэн</u> мэдээллийн алдааг залруулах</p> <p>(a) <u>НМҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь</u> тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд хэвлэн нийтэлсэн нисэхийн мэдээлэлд илэрсэн аливаа алдааг бүртгэх, шинжлэн шалгах, залруулах болон мэдээлэх журмыг тогтоосон байна.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-д заасан журам нь дараах шаардлагыг бататгасан байна:</p> <p><u>(1) тухайн алдааны үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөнөөс хамаарч хамгийн тохиромжтой хэлбэрээр залруулдаг байх;</u></p> <p>(2) дахин хэвлэн нийтэлсэн мэдээлэлд залруулга нь тодорхой <u>танигддаг</u> байх;</p> <p>(3) алдааны эх сурвалжийг таньж тогтоодог байх ба боломжтой бүх тохиолдолд <u>устгадаг</u> байх;</p> <p>(4) түгээгдсэн мэдээллийн зөрчлийг ИНД-12-ын дагуу <u>Даргад</u> мэдээлдэг байх.</p>	<p>175.63. Хэвлэгдсэн мэдээллийн алдааг залруулах</p> <p>(a) <u>Өргөдөл гаргагч нь</u> гэрчилгээгээр олгогдсон эрхийн дагуу хэвлэсэн нисэхийн мэдээлэлд илэрсэн алдааг бүртгэх, шинжлэн шалгах, залруулах, илтгэх журмыг тогтооно.</p> <p>(б) Энэ зүйлийн (a)-д заасан журамд дараах зүйлсийг тусгана: үйл ажиллагаанд нөлөөлөх байдлаас нь шалтгаалан алдааг хамгийн тохиромжтой аргаар залруулах;</p> <p>1/ дахин хэвлэгдсэн мэдээлэл дэх залруулгыг тодорхой <u>тэмдэглэх</u>;</p> <p>2/ алдааны эх үүсвэрийг тодорхойлж <u>арилгах</u> боломжит арга хэмжээ авах;</p> <p>3/ зарласан мэдээлэлтэй холбогдсон зөрчлийн талаар ИНД-12-ын дагуу <u>ИНЕГ</u>-ын даргад мэдэгдэх.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Amend.1-ээр нэмэгдсэн</p>
<p>175.65. Бүртгэл</p> <p>(a) <u>НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Ерөнхий</u> заавартаа заасан НМҮ-нд шаардлагатай бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах,</p>	<p>175.65. Бүртгэл</p> <p>(a) <u>Өргөдөл гаргагч нь Үйл ажиллагааны</u> заавартаа тусгагдсан эрхлэх НМҮ-нд шаардлагатай бүртгэлийг хөтлөх, индексжүүлэх, хадгалах, <u>шинэчлэх</u>, устгах</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>индексжүүлэх, хадгалах, хөтлөх болон устгах журмыг тогтоосон байх үүрэгтэй.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-д заасан журам нь дараах шаардлагыг <u>бататгасан</u> байх ёстой:</p> <p>(1) хүлээн авсан болон түгээсэн бүх нисэхийн мэдээллийг дэс дугаар болон <u>хугацаагаар нь хялбар таньж тогтоох боломжтой бүртгэлтэй байх, нэмэлт мэдээллийг ижил төстэй байдлаар бататгадаг байх ба шаардлагатай тохиолдолд таньж тогтоодог байх;</u></p> <p>(2) хүсэлт гаргагчийн, нисэхийн мэдээллийг шалгах, боловсруулах болон хэвлэн нийтлэх эрх олгосон ажилтан бүрийн бүртгэлтэй байх;</p> <p>(3) 175.63-т шаардсан журмын дагуу алдааг залруулсан тохиолдол бүрийн <u>бүртгэлтэй байх;</u></p> <p>(4) [хүчингүй]</p> <p>(5) бүх бүртгэл нь гаргацтай бөгөөд <u>байнгын, арилдаггүй хэлбэртэй</u> байх;</p> <p>(6) NOTAM, AIP-ын Нэмэлт болон AIC-ыг цуцалснаас хойш 30 хоног, бусад бүх бүртгэлийг 5 жилээс доошгүй хугацаагаар хадгалдаг байх.</p>	<p>журмыг тогтооно.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-д заасан журамд дараах зүйлсийг <u>тусгана:</u></p> <p>1/ хүлээн авсан болон түгээсэн бүх нисэхийн мэдээллийн бүртгэл бүр дэс дугаар, огноотой байх ба түүнд <u>холбогдолтой нэмэлт мэдээллүүдийг үүнтэй ижил байдлаар бүртгэж баталгаажуулах;</u></p> <p>2/ нисэхийн мэдээллийг шалгах, боловсруулах, хэвлэх ажлыг хариуцсан ажилтан тус бүр бүртгэл хөтлөх</p> <p>3/ энэ дүрмийн 175.63 зүйлд заасан журмын дагуу алдааг залруулсан тохиолдол бүрт бүртгэл <u>хөтлөх;</u></p> <p><u>4/ энэ дүрмийн 175.67 зүйлд заасан шаардлагын дагуу байгууллагадаа явуулсан дотоод чанар хангалтын дүн шинжилгээ бүрт бүртгэл хөтлөх;</u></p> <p>5/ бүх бүртгэлүүд нь гаргацтай, <u>засваргүй</u> байх;</p> <p>6/ NOTAM мэдээ, НМЭ-ийн нэмэлт, Нисэхийн мэдээллийн цуврал (цаашид НМЦ гэх)-ын бүртгэлийг цуцалсанаасаа хойш 30-аас доошгүй хоног, НМЭ болон нислэгийн зургуудын бүртгэлийг 5-аас доошгүй жилийн хугацаанд хадгалах.</p>	
<p><u>175.67 Аюулгүй байдлын удирдлага</u> <u>НМҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ИНД-100.3-ын дагуу аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх болон үйл ажиллагаандаа мөрддөг байх үүрэгтэй.</u></p>	<p><u>175.67. Дотоод чанарын хангалт</u> <u>(a) Өргөдөл гаргагч нь энэ дүрмийн 175.59, 175.61 зүйлд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх шат бүрт чанарын удирдлага гүйцэтгэхэд шаардлагатай журам, үйл явц, нөөцийг багтаасан, зөв зохион байгуулалттай чанарын тогтолцоог нэвтрүүлнэ.</u> <u>(б) Энэ зүйлийн (a)-гийн дагуу нэвтрүүлэх чанарын тогтолцоо нь Олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын чанар хангалтын 9000 бүлэг стандарт шаардлагыг хангаж холбогдох байгууллагаас гэрчилгээжсэн байвал зохино.</u> <u>(в) Өргөдөл гаргагчийн чанарын тогтолцооны хэрэгжилтийг аудитаар тогтоох ба аудитаар залруулах шаардлагатай үл тохирол илэрвэл түүний шалтгааныг</u></p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Amend.7-оор нэмэгдсэн</p>

тогтоож, тохирох арга хэмжээг авна. Аудитын бүх дүгнэлт болон үл тохирлыг залруулах арга хэмжээнүүд нь баримттай, зохих бүртгэлтэй байна.

(г) Өргөдөл гаргагч нь энэ дүрмийн 175.51 зүйлийн (а) хэсгийн 3-т заасан ажилтнуудын мэргэжлийн мэдлэг ба үр чадварыг бататгахын тулд анхан болон давтан шалгалт авч, үнэлэн зохих бүртгэлийг хөтөлнө. Давтан шалгалт нь ажилтнуудын мэргэжлийн мэдлэг ба үр чадварыг тогтоох, дутагдлыг залруулахад оршино.

(д) Өргөдөл гаргагч нь Үйл ажиллагааны зааварт тусгагдсан эрхлэх НМҮ-ний дотоод чанар хангалтын журмыг тогтооно.

(е) Энэ зүйлийн (д) хэсэгт заасан журамд дараах зүйлсийг тусгасан байна:

өргөдөл гаргагчийн хүрэхээр зорьж буй чанарын түвшин;
дотоод аудит хийх түвшин, давтамж болон түүнийг гүйцэтгэх ажилтан;

дотоод аудитыг дүгнэх чанар хангалт хариуцсан ажилтны үүрэг, хариуцлага;

дотоод аудитын үр дүнг бүртгэх болон түүнийг удирдах албан тушаалтанд илтгэх үйл ажиллагаа;

алдаа, зөрчил болон гомдол гэх мэт чанарын үзүүлэлтүүдийг тогтоох, зохицуулах арга хэлбэр;

дотоод аудитаар илэрсэн аливаа дутагдлыг залруулах арга;

дотоод аудитын бүх үйл явцын баримтжуулалтад тавигдах шаардлага;

аливаа өгөгдлийг хэвлэх, шинэчлэх эсхүл ашиглах явцад илэрсэн үл тохиролыг залруулахын тулд тухайн нисэхийн өгөгдлийн эх сурвалжийг үйл явцын бүх шатуудад мөшгөх боломжтой байлгах зохицуулалт;

нисэхийн мэдээлэл/өгөгдлийг энэхүү дүрмийн хавсралтад заасан өгөгдлийн чанарын шаардлага (нарийвчлалын хэмжээ, зөвшөөрөгдөх хэмжээ, бүрэн бүтэн байдал)-д нийцүүлэх болон өгөгдлийн мөшгөх боломжийг хангах зорилгоор шалгаж батлах, баталгаажуулах ажиллагаа;

нисэхийн өгөгдлийг ашиглахаар төлөвлөсөн хугацааны хэрэгжилт болон тогтоосон өдрүүдэд мэдээллийг түгээж

	<p><u>буй эсэхэд тавих хяналт:</u> <u>(ж) Чанар хангалт хариуцсан удирдах ажилтан нь хэвлэсэн нисэхийн мэдээллийн нийцэл, үнэн зөв, маягт, загвар, цаг хугацаа, түгээсэн байдлын талаар байгууллагын удирдах албан тушаалтантай шууд харьцах эрхтэй.</u></p>	
<p>175.69. НМҮБ-ын Ерөнхий заавар (а) <u>НМҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журмыг багтаасан Ерөнхий зааврыг Даргад</u> хүргүүлэх үүрэгтэй: (1) <u>Ерөнхий</u> заавар болон түүнд багтсан бусад заавар нь дараах шаардлагыг хангасан болохыг <u>бататган, хүсэлт гаргагчийн байгууллагын нэрийн өмнөөс Гүйцэтгэх захирал</u> гарын үсэг зурсан мэдэгдэл: (i) <u>тухайн байгууллагыг тодорхойлох ба энэ Дүрмийн байнгын хэрэгжилтийг бататгах хэлбэр болон аргыг харуулах;</u> (ii) <u>хүсэлт гаргагчийн байгууллагын ажилтнууд түүнийг байнга дагаж мөрддөг байх;</u> (1А) <u>175.67-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хувьд:</u> (i) <u>ИНД-100.3(б)-д шаардсан бүх баримт бичиг;</u> (ii) <u>НМҮБ-ын гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргаагүй хүсэлт гаргагчийн хувьд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэхийг дүрслэн харуулсан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө;</u> (2) 175.51(а)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын албан тушаал, нэр; (3) 175.51(а)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын дараах үүрэг, хариуцлагыг: (i) <u>тухайн байгууллагын нэрийн өмнөөс Дарга, эсхүл ИНЕГ-тай шууд харьцах тэдний хариуцсан асуудал;</u> (ii) <u>аюулгүй байдлын удирдлагын үүрэг хариуцлага;</u> (4) 175.51(а)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын хариуцлагын шугаман хамаарлыг харуулсан байгууллагын бүтцийн зураг; (5) энэ зүйлийн (а)(6)-д заасан НМҮ-г үзүүлэх ажилтнуудын бүтцийн дэлгэрэнгүй мэдээлэл;</p>	<p>175.69. Байгууллагын <u>үйл ажиллагааны</u> заавар (а) <u>Өргөдөл гаргагч нь</u> дараах баримт бичгийг агуулсан Үйл ажиллагааны зааврыг <u>ИНЕГ</u>–ын даргад хүргүүлнэ. 1/ <u>үйл ажиллагааны</u> заавар болон түүнд орсон журам, зааврыг энэ дүрэмтэй нийцэж <u>боловсруулагдсан бөгөөд түүнийг тасралтгүй хэрэгжүүлж, мөрдөгдөх талаар байгууллагын удирдах албан тушаалтны бичгээр гаргасан батламж;</u> 2/ энэ дүрмийн 175.51 зүйлийн (а) хэсгийн 1/, 2/-т заасан удирдах ажилтнуудын нэрс, албан тушаал; 3/ энэ дүрмийн 175.51 зүйлийн (а) хэсгийн 2/-т заасан ажилтнуудын өөрийн байгууллагыг төлөөлөн ИНЕГ-ын даргатай шууд харьцах чиглэл, тэдний хүлээх үүрэг хариуцлагууд; 4/ энэ зүйлийн (а) хэсгийн 2/-т заасан ажилтнуудын үүрэг, хариуцлагын холбоосыг харуулсан бүдүүвч; 5/ энэ зүйлийн (а) хэсгийн 6/-д заасан НМҮ-г эрхлэн явуулах ажилтнуудын үйл ажиллагааны зохион</p>	<p>-Орчуулга, найруулга зассан -Аmend.7-оор нэмэгдсэн</p>

<p><u>(5A) байгууллагын хүрээнд аюулгүй байдлын хариуцлагын шугаман хамаарлыг тодорхойлсон мэдээлэл;</u></p> <p>(6) гэрчилгээний дагуу <u>үзүүлэх</u> НМҮ-ний жагсаалт;</p> <p>(7) нислэгийн <u>өмнөх</u> мэдээллийн үйлчилгээний хувьд, 175.55-д шаардсан газарзүйн бүс, аэродром болон агаарын замын <u>дэлгэрэнгүй мэдээлэл</u>;</p> <p>(8) 157.103(b)(1) болон 175.105(1)-д шаардсан нэгжийн байршил болон хаягийн <u>дэлгэрэнгүй мэдээлэл</u>;</p> <p>(9) хэвлэн <u>нийтэлсэн</u> нисэхийн мэдээллийн хувьд, 175.57(a)(1)-д шаардсан хүсэлт гаргагчийн <u>формат болон стандартын дэлгэрэнгүй</u> мэдээлэл;</p> <p>(10) дараах шаардлагатай холбоотой <u>хүсэлт гаргагчийн журмын дэлгэрэнгүй</u>:</p> <p>(i) ажилтны ур чадвар;</p> <p>(ii) баримт бичгийн хяналт;</p> <p>(iii) мэдээлэл цуглуулах;</p> <p>(iv) нисэхийн мэдээллийг хэвлэн <u>нийтлэх</u>;</p> <p>(v) хэвлэн нийтэлсэн мэдээллийн алдааг залруулах;</p> <p>(vi) бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, <u>арчлах</u> болон устгах;</p> <p>(11) <u>Ерөнхий зааврыг</u> хянах, <u>нэмэлт</u> өөрчлөлт оруулах болон <u>түгээх</u> журам.</p> <p><u>(b) Хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой.</u></p>	<p>байгуулалтын бүтэц;</p> <p>6/ гэрчилгээнд тусгах НМҮ-ний жагсаалт;</p> <p>7/ энэ дүрмийн 175.55 зүйлд заасан НӨМҮ-ний газарзүйн бүс, аэродромууд ба тэдгээрээс <u>эхлэх</u> агаарын замууд;</p> <p>8/ энэ дүрмийн 175.103 зүйлийн (б) хэсгийн 1/ болон 175.105 зүйлийн (а) хэсгийн 1/-ийн дагуу байгуулагдсан нэгжүүдийн байрлал болон хаягийн <u>жагсаалт</u>;</p> <p>9/ энэ дүрмийн 175.57 зүйлийн (а) хэсгийн 1/-д заасны дагуу хэвлэх нисэхийн мэдээллийн <u>маягт болон загвар</u>;</p> <p>10/ <u>НМҮ-ний үйл ажиллагаанд</u> шаардагдах дараах журмууд:</p> <p>10.1. <u>ажилтныг сонгон шалгаруулах, сургах талаар</u>;</p> <p>10.2. ажилтны ур чадварын талаар;</p> <p>10.3. баримт бичгийн хяналтын талаар;</p> <p>10.4. мэдээлэл цуглуулах талаар;</p> <p>10.5. нисэхийн мэдээлэл хэвлэх талаар;</p> <p>10.6. хэвлэгдсэн мэдээллийн алдааг залруулах талаар;</p> <p>10.7. бүртгэлийг цуглуулах, индексжүүлэх, хадгалах, <u>шинэчлэх</u>, устгах талаар;</p> <p><u>10.8. дотоод чанар хангалтын талаар</u>;</p> <p><u>10.9. онцгой нөхцөл байдлын үед авах арга хэмжээний талаар</u>.</p> <p>11/ <u>үйл ажиллагааны</u> зааврыг хянах, өөрчлөх болон <u>тараах</u> журам.</p>	<p>-Орхигдуулсан заалтыг нөхөж оруулсан</p>
<p>С бүлэг - Үйл ажиллагааны шаардлага</p>	<p>В БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА</p>	
<p>175.101. <u>Байнгын хэрэгжилт НМҮБ-ын</u> гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан байна:</p>	<p>175.101. <u>Ерөнхий шаардлага</u> (а) Гэрчилгээ эзэмшигч нь дараах үндсэн шаардлагыг биелүүлнэ:</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>(1) <u>Ерөнхий</u> заавартаа заасан ажлын байрлал тус бүрд, тухайн зааврын нэгээс доошгүй хүчинтэй, бүрэн хувийг хадгалдаг байх;</p> <p>(2) <u>Ерөнхий</u> заавартаа заасан бүх журам, стандартыг дагаж мөрддөг байх;</p> <p>(3) <u>Ерөнхий</u> зааврын холбогдох бүлэг бүрийг шаардлагатай ажилтан ажил үүргээ гүйцэтгэхэд ашиглах боломжтой байлгах;</p> <p>(4) энэ Дүрмийн дагуу гэрчилгээжүүлэлтэд тогтоосон В Бүлгийн шаардлага болон стандартыг байнга хангадаг байх;</p> <p>(5) САА 24175/01 маягтад шаардсан үйлчилгээ эрхлэх хаяг, утасны дугаар, эсхүл факсын дугаарын аливаа өөрчлөлтийг тухайн өөрчлөлт орсноос хойш <u>28 хоногийн дотор Даргад</u> мэдэгддэг байх.</p>	<p>1/ <u>Үйл ажиллагааны</u> зааврын хүчин төгөлдөр, нэгээс доошгүй хувийг <u>үйл ажиллагаа эрхлэх нэгж бүрт байлгах</u>;</p> <p>2/ <u>Үйл ажиллагааны</u> зааварт тусгагдсан журам, стандартуудыг мөрдөж <u>ажиллах</u>;</p> <p>3/ ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах <u>Үйл ажиллагааны</u> зааврын зохих хэсгүүдийг тухайн ажилтны ажлын байранд бэлэн байлгах;</p> <p>4/ энэ дүрмийн Б бүлэгт тавигдсан стандарт, шаардлагыг байнга мөрдөж ажиллах;</p> <p>5/ байгууллагын хаяг болон телефон утас, факсын дугаар зэрэг харилцах хаягт өөрчлөлт орохоор бол <u>ИНЕГ</u>-н даргад <u>нэн даруй</u> мэдэгдэх;</p> <p>6/ <u>НМҮБ-ыг зохион байгуулах болон нисэхийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, түгээх үйл ажиллагаанд хүний хүчин зүйлийн зарчмуудыг тооцох</u>;</p> <p>7/ <u>НМҮ-ний автомат системийн мэдээллийн санд чанарын шаардлага хангасан нисэхийн мэдээлэл/өгөгдлийг цаг хугацаанд нь оруулж байх.</u></p>	<p>-Amend.1-ээр нэмэгдсэн</p>
<p>175.103. <u>AIP-ын үйлчилгээ</u></p> <p>(a) AIP-ын үйлчилгээ үзүүлдэг <u>НМҮБ-ын</u> гэрчилгээ эзэмшигч нь дараах мэдээллийг хэвлэн нийтлэх үүрэгтэй:</p> <p>(1) D Бүлгийн дагуу Монгол Улсын <u>AIP</u>;</p> <p>(2) 175.155-ын дагуу Өөрчлөлт;</p> <p>(3) 175.157-гийн дагуу <u>AIP-ын Нэмэлтээр</u> дараах мэдээллийг:</p> <p>(i) 3 сар, эсхүл түүнээс урт хугацаатай түр өөрчлөлт;</p> <p>(ii) их хэмжээний текст, эсхүл графикийг багтаасан, 3 сараас бага хугацаатай мэдээлэл;</p> <p>(4) E Бүлгийн дагуу <u>AIC</u>;</p>	<p>175.103. <u>Нисэхийн мэдээллийн эмхтгэлийн үйлчилгээ</u></p> <p>(a) НМҮ-ний НМЭ-ийн төрлөөр гэрчилгээ эзэмшигч нь дараах бүтээгдэхүүнийг хэвлэх үүрэгтэй:</p> <p>1/ энэ дүрмийн Г Бүлгийн дагуу Монгол Улсын НМЭ-ийг;</p> <p>2/ энэ дүрмийн 175.155 зүйлд заасны дагуу НМЭ-ийн өөрчлөлтийг;</p> <p>3/ 3 сар буюу түүнээс дээш хугацаатай түр шинж чанартай болон 3 сараас бага хугацаатай,</p> <p>4/ их хэмжээний текст, эсхүл зураг агуулсан мэдээллийг энэ дүрмийн 175.157 зүйлийн дагуу НМЭ-ийн нэмэлтээр;</p> <p>5/ энэ дүрмийн Д Бүлгийн дагуу НМЦ-ыг.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Amend.2-оор нэмэгдсэн</p>

<p>(b) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (а)-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:</p> <p>(1) бусад улсын НМҮБ-тай Монгол Улсыг төлөөлөн харилцаж NOTAM-аас бусад Нисэхийн мэдээллийн нэгдсэн багцыг харилцан солилцох нэгжийг томилох;</p> <p>(2) тухайн мэдээллээр хангахтай холбоотой гарч болох төлбөрийг хийсний дараа Монгол Улсын AIP, AIP-ын өөрчлөлт, AIP-ын Нэмэлт болон AIC-ыг аливаа этгээд ашиглах боломжтой байлгах;</p> <p>(3) 175.61(c)(3)-ын дагуу Монгол Улсын AIP, AIP-ын Өөрчлөлт, AIP-ын Нэмэлт нислэгийн зураг болон AIC-ыг түгээх тогтолцоог бүрдүүлэх;</p> <p>(4) Монгол Улсын AIP-ын хэсгээр хэвлэн нийтлэгдсэн нислэгийн зураг бүрийг нислэгийн зургийн холбогдох стандартад нийцэж байгааг бататгах;</p> <p>(5) дараахаас бусад тохиолдолд, 175.59(b)(1)-д заасан мэдээлэгч байгууллагаас ирсэн бүх нисэхийн мэдээлэлд зохицуулалт хийх:</p> <p>(i) NOTAM гаргахыг яаралтай шаардсан, үйл ажиллагааны хойшлуулшгүй чухал ач холбогдолтой мэдээлэл;</p> <p>(ii) зөвхөн NOTAM гаргахыг шаарддаг, 3 сараас бага хугацаатай түр мэдээлэл.</p>	<p>(б) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (а) хэсэгт дурдсан үйл ажиллагаанаас гадна:</p> <p>1/ бусад улсын НМҮБ-тай NOTAM мэдээнээс бусад нисэхийн мэдээллийн нэгдсэн багцын элементийг шууд солилцох нэгжийг томилох;</p> <p>2/ ICAO-ын гишүүн улсын НМҮБ-тай харилцан тохиролцсоны үндсэн дээр, нисэхийн мэдээллийн нэгдсэн багцын элементийг үнэгүй солилцох, төлбөртэй үйлчлэх нөхцлийг бүрдүүлэх;</p> <p>3/ ICAO-ын гишүүн бус улстай нисэхийн мэдээллийн нэгдсэн багцын элементүүд, агаарын навигацийн бичиг баримт, хууль эрх зүйн баримт бичгүүдийг цаасан болон электрон хэлбэрээр солилцох шаардлага гарсан тохиолдолд тухайн улстай гэрээ байгуулах.</p> <p>4/ Монгол Улсын НМЭ, түүний өөрчлөлт, НМЭ-ийн нэмэлт, нислэгийн зургийг энэ дүрмийн 175.61-р зүйлийн (в) хэсгийн 3/-ын дагуу түгээх тогтолцоог бүрдүүлэх;</p> <p>5/ НМЭ-д орох нислэгийн зургийг холбогдох зургийн зааварт нийцүүлэх;</p> <p>6/ энэ дүрмийн 175.59 зүйлд заасны дагуу хүлээн авсан, NOTAM мэдээгээр зарлагдахаас бусад нисэхийн мэдээллийг зохицуулж нисэхийн мэдээллийн нэгдсэн багцын тохирох элементэд хуваарилна.</p>	<p>-Орхигдуулсан заалтыг нөхөж оруулсан</p>
<p>175.105 NOTAM-ын үйлчилгээ NOTAM-ын үйлчилгээ үзүүлдэг НМҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>(1) Монгол Улсын олон улсын NOTAM-ын нэгжийг томилох;</p> <p>(2) олон улсын NOTAM-ын нэгжийг 24 цагаар</p>	<p>175.105. NOTAM <u>мэдээний</u> үйлчилгээ</p> <p>(а) Нисэхийн мэдээллийн үйлчилгээний NOTAM мэдээний төрлөөр гэрчилгээ эзэмшигч нь дараах үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>1/ Монгол Улсын олон улсын NOTAM -ын нэгжийг томилно;</p> <p>2/ олон улсын NOTAM -ын нэгж нь 24 цагийн турш</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>ажиллуулах;</p> <p>(3) NOTAM солилцох зорилгоор олон улсын бусад NOTAM-ын нэгжтэй <u>гэрээ байгуулах</u>;</p> <p>(4) дараах шаардлагыг бататгах: <u>(i) олон улсын NOTAM-ын нэгж нь AFS-нд холбогдсон байх;</u> <u>(ii) AFS-ийн холболт нь хэвлэлийн өгөгдөл дамжуулах (printed communication) чадвартай байх;</u> <u>(iii) олон улсын NOTAM-ын нэгж нь холбоогоор түгээгддэг NOTAM хүлээн авах болон гаргах чадвартай байгууламжтай байх;</u></p> <p>(5) 175.59-ийн дагуу хүлээн авсан мэдээллээр NOTAM гаргах шаардлагатай тохиолдолд, F Бүлгийн дагуу түргэн шуурхай NOTAM гаргана;</p> <p>(6) AFS-ээр дамжуулан, хүчинтэй байгаа NOTAM-ын шалгах хуудсыг 1 сараас ихгүй үечлэлтэй байхаар гаргана.</p>	<p>үйл ажиллагаа явуулна;</p> <p>3/ бусад олон улсын NOTAM -ын нэгжтэй харилцан <u>зөвшилцсөний</u> үндсэн дээр NOTAM мэдээ солилцоно;</p> <p>4/ энэ дүрмийн 175.59 зүйлд заасны дагуу хүлээн авсан мэдээллийг NOTAM мэдээгээр зарлах шаардлагатай үед E бүлгийн дагуу яаралтай боловсруулан тараана;</p> <p>5/ хүчинтэй NOTAM-ын хяналтын жагсаалтуудын хоорондын зай нь нэг сараас илүүгүй байна.</p>	<p>-Орхигдуулсан заалтыг нөхөж оруулсан</p>
